

ӨМНӨХ ҮГ

Өнөөдөр хүн ам, хөгжлийн асуудал бүх нийтийн үйл хэрэг гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч, энэ чиглэлээр хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажилд ихээхэн ач холбогдол өгч байна. Хүн ам, хөгжлийн асуудлыг сонирхогч эрдэмтэн судлаачид, асуудал хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид, бодлого, боловсруулагчид, шийдвэр гаргагчдын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах асуудал ч зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр МОН/02/P09 төслийн хүрээнд **Дэлхийн хүн амын өдөрт зориулан** “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 8 дахь дугаарыг бэлтгэн эрхэм уншигч та бүхэндээ толилуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт бүс нутгууд дахь хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын асуудал, өрхийн ядуурах эмзэг байдал, монголын хотжилтын процесс, залуучуудын боловсрол дахь хүйсийн тэгш бус байдал, гэр бүлийн хүчирхийлэлд үзүүлж буй нөлөөлөл, эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал зэрэг өөрийн орны судлаачдын хийсэн судалгааны бүтээлүүдээс гадна Монголын хүн амын өсөлтийг дэмжих бодлогын талаар гадаадын судлаачийн бичсэн санал, эргэцүүллийг нийтэлж байна. Сэтгүүлийн “Сургалт” хэсгээс нийгмийн даатгалын тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох асуудлын талаар танилцаарай.

Түүнчлэн “Хот Хөдөө дэх Хүний Хөгжлийн ялгаатай байдал” сэдэвт 2003 оны Монголын Хүний Хөгжлийн Илтгэлийг бичих бэлтгэл ажиллагааны хүрээнд оюутан, залуучуудын дунд зохион явуулсан ЭССЭ бичих уралдаанд тэргүүн байр эзэлсэн бүтээлүүдээс та бүхэнд хүргэж байна.

Монгол улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, оюутан залуучууд та бүхэндээ сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье. Мөн Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж, техникийн туслалцаа үзүүлж байдаг Хүн Амын Сургалт, Судалгааны Төвийн хамт олон болон санхүүгийн дэмжлэг үзүүлж буй НҮБ-ийн Хүн Амын Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн Газарт сэтгүүлээрээ дамжуулан чин сэтгэлээсээ талархаж байдгаа дахин илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тэлэх болтугай.

**Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгийн
Гүйцэтгэх Захирал
А. Солонго**